

## ГАРЧИГ

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	2
I.НУТАГ ДЭВСГЭР, ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ .....	3
II.ХҮН АМ .....	4
III.ХӨДӨЛМӨР .....	7
IV.ХҮН АМЫН НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ .....	8
V.НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ .....	13
VI.ЭРҮҮЛ МЭНД .....	15
VII.БОЛОВСРОЛ.....	16
VIII. ГЭМТ ХЭРЭГ .....	18
IX. МӨНГӨ, ЗЭЭЛ.....	20
X. ТӨСӨВ.....	21
XI.ҮНЭ .....	22
XII.ХӨДӨӨ АЖ АХУЙ.....	23
XIII. АЖ ҮЙЛДВЭР.....	29
XIV. ХАВСРАЛТ .....	34

## Үндсэн үзүүлэлтүүд

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эцсийн байдлаар

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2019 I-XII	2020 I-XII	Өөрчлөлтийн хувь
Нийт хүн ам	мян.хүн	57.5	58.3	101.5
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая.төгрөг	16 810.8	14 270.3	84.9
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт	сая.төгрөг	17 346.7	14 940.1	86.1
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	964	996	103.3
Бүртгэлтэй ажилгүй иргэдээс шинээр ажилд орсон иргэд	хүн	217	117	53.9
Амьд төрсөн хүүхэд	хүн	1 368	1 406	102.8
Амаржсан эх	хүн	1 355	1 395	103.0
Нас баралт	хүн	303	282	93.1
Нялхсын эндэгдэл	хүн	20	12	60.0
Нялхсын эндэгдлийн түвшин	1000 амьд төрөлтөд ногдох	14.6	8.5	58.1
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	хүн	6	1	16.7
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	хүн	416	305	73.3
Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид	хүн	11 699	11 901	101.7
Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхэд	хүн	4 322	4 114	95.2
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	235	151	64.3
Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ	сая.төгрөг	1 196.4	697.0	58.3
Бүртгэгдсэн гэмт хэрэгт холбогдсон хүний тоо	хүн	166	155	93.4
Хадгаламжийн хэмжээ	сая.төгрөг	92 781.5	127 260.0	137.2
Зээлийн өрийн үлдэгдэл	сая.төгрөг	127 665.0	124 537.7	97.6
Үүнээс: чанаргүй зээл	сая.төгрөг	1 026.0	1 068.5	104.1
Хэрэглээний үнийн индекс/ өмнөх сартай харьцуулсан/	хувь	100.1	100.4	100.3
Хэрэглээний үнийн индекс/өмнөх оны эцэстэй харьцуулсан/	хувь	105.1	102.8	97.8
Малын тоо	мян.толгой	3 597.7	3 310.8	92.0
Үүнээс: Адуу	мян.толгой	132.4	122.1	92.2
Үхэр	мян.толгой	84.5	75.9	89.8
Тэмээ	мян.толгой	44.4	43.9	98.9
Хонь	мян.толгой	1 066.7	945.7	88.7
Ямаа	мян.толгой	2 269.6	2 123.2	93.5
Хээлтэгч малын тоо	мян.толгой	1 524.9	1 380.4	90.5
Үүнээс: Гүү	мян.толгой	44.7	42.4	94.9
Үнээ	мян.толгой	34.5	30.4	88.1
Ингэ	мян.толгой	15.2	15.6	102.6
Эм хонь	мян.толгой	462.9	405.1	87.5
Эм ямаа	мян.толгой	967.5	886.8	91.7

# I.Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж

## ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ, НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭ


№	Сумын нэр	Сумын төвийн баг	Багийн тоо	Нутаг дэвсгэрийн хэмжээ, км <sup>2</sup>	Алслалт, километр	
					Улаанбаатараас	Аймгийн төвөөс
<b>Бүгд</b>			<b>88</b>	<b>141447</b>	-	-
1	Алтай	Баян-овоо	4	20256	1319	318
2	Баян-уул	-	6	5836	1112	146
3	Бигэр	-	5	3826	961	108
4	Бугат	Баянгол	5	9921	1204	219
5	Дарив	Үйлдвэр	4	3523	1187	212
6	Дэлгэр	Баянсан	5	6625	913	88
7	Жаргалан	-	3	3683	1047	102
8	Тайшир	-	3	3913	991	43
9	Тонхил	-	5	7322	1210	218
10	Төгрөг	-	5	5343	1149	148
11	Халиун	-	4	5214	1056	87
12	Хөхморьт	Сайн-Уст	5	6314	1182	215
13	Цогт	-	7	16618	1040	187
14	Цээл	-	4	5631	1136	167
15	Чандмана	Талын шанд	5	4629	955	189
16	Шарга	Баянгол	4	5566	1080	79
17	Эрдэнэ	-	4	25066	989	223
18	Есөнбулаг	-	10	2161	1037	-

	Хэмжээ
Нутаг дэвсгэр /мян.км <sup>2</sup> /	141.4
Хилийн урт /км/	2040
Өмнө цэгээс хойд цэг хүртэлх зай /км/	638
баруун цэгээс зүүн цэг хүртэлх зай/км/	413
Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээ /мян.км <sup>2</sup> /	1564.1
Өмнөговь аймаг хамгийн том нутаг дэвсгэртэй /мян.км <sup>2</sup> /	165.4
Орхон аймаг, хамгийн бага нутаг дэвсгэртэй /мян.км <sup>2</sup> /	0.8
Говь-алтай аймаг, улсад нутаг дэвсгэрээрээ II байранд орж байна	-
Монгол улс дэлхийд нутаг дэвсгэрээрээ XIX байранд ордог	-


## II. Хүн ам

Говь-алтай аймгийн суурин хүн амын тоо 2020 онд 58343 байгаа нь өмнөх оны 864 (1.5%) мянган хүнээр өсжээ. хүн амын 49.9 хувь нь эрэгтэйчүүд, 50.1 хувь нь эмэгтэйчүүд байна. хүйсийн харьцаа нь 100 эмэгтэйд ноогдох эрэгтэйн тоогоор илэрхийлэгддэг. Манай аймгийн хувьд 2020 онд хүйсийн харьцаа 100 эмэгтэй 100 эрэгтэй хүүхэд ноогдож байна. Харин нийт хүн амд хүйсийн харьцаа 99.7 байна. сүүлийн 8 жилийн үзүүлэлтээс харахад 2013 онд хүйсийн харьцаа 94.3 байснаа өссөөр 2020 онд 99.7 болсон байна.



Хүн амын тоо, мян.хүн, 2013-2020 он



Хүйсийн харьцаа, 2013-2020 он




Хүн амын нас, хүйсийн суваргаар хүн амын нас, хүйсийн бүтцийг зураглан харуулдаг. суваргын баруун, зүүн талд хүйсээр ялган, насны бүлгийн хувьд хамгийн залуугаас эхлэн өсөх дарааллаар доороос дээш суварган хэлбэртэй байна. Хүн амын нас, хүйсийн суваргыг зурахдаа хүн амын бодит тоо болон нийт хүн амд эзлэх хувийн жингээр зурна. хувийн жингээр зурахдаа нийт хүн амыг 100 хувь гэж тооцно. Аймгийн 2020 оны хүн амыг нас хүйсийн суваргаас харахад 0-34 насны хүн амд эрэгтэйчүүдийн эзлэх хувь илүү байхад 45-с дээш насныханд эмэгтэйчүүдийн эзлэх хувь их байна. Аймгийн хэмжээнд 70 дээш насны 1480 өндөр настан байгаагийн 67.9 хувь нь эмэгтэйчүүд байна. 2020 оны эцсээр аймгийн хэмжээнд 97-с дээш насны 7 өндөр настан байгаа бөгөөд 5 эмэгтэй хүн байна.



Хүн амын 18.0 мянган хүн (30.9%) 0-14 насны хүүхэд, 36.1 мянган хүн (61.8%) 15-69 насны хүн ам, 4.2 мянган хүн ам (7.3%) 60 дээш насны хүн ам эзэлж 2019 онтой харьцуулахад хүүхдийн эзлэх хувь 0.3 пунктээр, 60 дээш насны хүн амын эзлэх хувь 0.4 пунктээр нэмэгдэж, хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь 0.7 пунктээр буурсан байна.

### Хүн амын зүйн ачаалал


Хүн ам зүйн ачааллыг тооцохдоо тэжээгч насны бүлэг буюу 15-64 нас, тэжээлгэгч бүлэг буюу 15-аас доош, 64-с дээш насны хүн амыг хамруулан тооцдог. Энэ үзүүлэлт нь хөдөлмөрийн насны нийт хүн амд хөдөлмөрийн бус насны хэдэн хүн ноогдож буйг харуулна.




Аймгийн хүн ам зүйн нийт ачаалал 2013 оноос хойш өссөн хандлагатай харагдаж байна. хүн ам зүйн ачаалал нь өсч байгаа нь сөрөг үзүүлэлт юм. Ачааллыг хүүхэд, хөгшин насны бүлгээр тооцож үзвэл 2020 онд өмнөх оны мөн үеэс хүүхдийнх 0.8, хөгшид нь 1.0 пунктээр өсчээ.

### Хүн амын нягтрал


Манай аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 141447 кв.км бөгөөд нэг км квадратад 0.4 хүн ноогдож байна. Хүн амын нягтралаар есөнбулаг сум хамгийн өндөр буюу 1 кв.км-д 8.7 хүн ноогдож байна. Энэ нь аймгийн төв нь гэрэл цахилгаантай үйлдвэрлэл үйлчилгээ илүү хөгжсөн түүнийгээ дагаад хүн ам ихтэй, нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ ч харьцангуй бага байгаатай холбоотой юм.



## БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, 2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН ЭЦЭСТ



### Насны бүлгээр



Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд, 2020 онд



### III.Хөдөлмөр



#### БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН

Халамжийн үйлчилгээний газарт ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны 12 дугаар сарын эцэст 996 байгаагийн 664 (66.7 %) ажил хөдөлмөр эрхлээгүй бүртгэлтэй иргэн, 332 (33.3%) одоо ажил хөдөлмөр эрхлэж байгаа ч бүртгэлтэй иргэн байна. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 32 (3.3%) хүнээр, өмнөх сараас 87 (9.6%) хүнээр өсөж, бүртгэлтэй ажилгүй иргэдийн 481 (48.3%) эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд ажилгүй иргэдийн 23 (2.3%) хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа ба 10 (43.5%) эмэгтэйчүүд байна.

2020 оны 12 дугаар сард ажилгүй 280 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 117 иргэн ажилд зуучлагдан орж, 193 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн хувьд ажил хайж буй шалтгаанаар нь задлан харахад хамгийн өндөр хувийг цалин орлого хүрэлцэхгүй иргэд 22.9 хувь нь, хамгийн бага хувийг цэргээс халагдсан иргэд буюу 1.1 хувь нь эзэлж байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 52.6 хувийг бүрэн дунд, 28.7 хувийг дипломын болон бакалаврын дээд, 7.4 хувийг техник мэргэжлийн, 4.2 хувийг суурь, 3.8 хувийг тусгай мэргэжлийн дунд, 1.8 хувийг бага, 1.5 хувийг ямар ч боловсролгүй иргэд эзэлж байна.

Мөн аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 48.7 хувийг 15-34 насны залуучууд, 45.0 хувийг 35-54 насныхан, 6.3 хувийг 55 дээш насныхан тус тус эзэлж байна.



## Ойлголт, тодорхойлолт:

Ажил хайгч иргэн: Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.

Бүртгэлтэй ажилгүй иргэд: Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

## IV. Хүн амын нийгмийн зарим үзүүлэлт


Аймгийн хэмжээнд 2020 онд 1103 өнчин хүүхэд байгаагийн 55 (5.0%) нь бүтэн өнчин хүүхэд, 1048 (95.0%) нь хагас өнчин хүүхэд байна. Нийт өнчин хүүхдийн 140 (12.7%) нь 0-4 насны, 277 (25.1%) нь 5-9 насны, 397 (36.0%) нь 10-14 насны, 103 (9.3%) нь 15 насны, 85 (7.7 %) нь 16 насны, 101 (9.2%) нь 17 насны хүүхэд байна.

Бүтэн өнчин хүүхдийн тоо 2020 онд өмнөх оноос 1 (1.9%), хагас өнчин хүүхдийн тоо 79 (8.2%) өсжээ.

БҮТЭН, ХАГАС ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, жил бүрийн эцсийн байдлаар


Сум	Бүтэн өнчин хүүхэд				Хагас өнчин хүүхэд			
	2017	2018	2019	2020	2017	2018	2019	2020
<b>Бүгд</b>	<b>51</b>	<b>54</b>	<b>54</b>	<b>55</b>	<b>969</b>	<b>995</b>	<b>969</b>	<b>1048</b>
Есөнбулаг	19	20	25	23	469	406	469	449
Алтай	1	4	5	4	30	51	30	47
Баян-Уул	5	4	3	2	39	60	39	54
Бигэр	1	1	1		25	28	25	28
Бугат	4	1			25	14	25	21
Дарви		1	1	1	16	22	16	32
Дэлгэр	2				34	33	34	38
Жаргалан				1	15	11	15	7
Тайшир	2	1	1	1	18	12	18	11
Тонхил		1	3	3	27	26	27	31
Төгрөг	1	1	1	1	25	48	25	38
Халиун	1	5	5	5	60	52	60	68
Хөхморьт	3	1		3	37	39	37	35
Цогт	1	4	3	2	38	61	38	42
Цээл	2	4	3	4	27	28	27	53
Чандмань	1	1			33	33	33	26
Шарга	3	2	1	1	21	20	21	27
Эрдэнэ	5	3	2	4	30	51	30	41

ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ, өрхийн гишүүдийн тоогоор, жил бүрийн эцсийн байдлаар



Өрх толгойлсон эх 2020 онд 1703 болж өмнөх оноос 132 (7.2%)-оор, өрх толгойлсон эцэг 306 болж өмнөх оноос 9 (2.9%)-өөр тус тус буурчээ. өрх толгойлсон эхчүүдийн 841 (49.4%) нь 3 хүртэлх, 680 (39.9%) нь 3-5 хүртэлх, 182 (10.7%) нь 6, түүнээс дээш гишүүнтэй өрхийг толгойлж байна.

18 ХҮРТЭЛХ НАСНЫ 4, ТҮҮНЭЭС ДЭЭШ ХҮҮХЭДТЭЙ ӨРХИЙН ТОО, хүүхдийн тоогоор, 2020 оны эцсийн байдлаар




18 хүртэлх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 1049 байгаагийн 784 (74.7%) нь 4 хүртэлх, 170 (16.2%) нь 5 хүртэлх, 75 (7.1%) нь 6 хүртэлх, 20 (1.9%) нь 7, түүнээс дээш хүүхэдтэй өрх байна.

Ганц биеэрээ өрх үүсгэн амьдарч буй ахмад настан	2017	2018	2019	2020
<b>БҮГД</b>	<b>1273</b>	<b>1261</b>	<b>1399</b>	<b>1463</b>
60, түүнээс дээш настай эрэгтэй	248	254	255	277
55, түүнээс дээш настай эмэгтэй	1025	1007	1144	1186

Ганц биеэрээ амьдарч буй ахмад настай хүний тоо 2020 оны эцэст 1463 болж, өмнөх оноос 64 (4.6%)-өөр өссөн байна. Ганц биеэрээ амьдарч буй өндөр настай нийт хүний 277 (18.9%) нь 60, түүнээс дээш настай эрэгтэйчүүд, 1186 (81.1%) нь 55, түүнээс дээш настай эмэгтэйчүүд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн 2020 оны эцэст 3116 болж, өмнөх оны мөн үеэс 100 (3.3%)-аар өссөн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний 19.9 хувь нь хөдөлгөөний согогтой, 7.7 хувь нь сонсгол, 2.7 хувь нь хэл ярианы согогтой, 6.8 хувь нь хавсарсан согогтой, 11.7 хувь нь харах эрхтний өөрчлөлттэй, 35.4 хувь нь бусад, 15.6 хувь нь сэтгэцийн бэрхшээлтэй хүн байна.

#### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, жил бүрийн эцэст



#### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, сумаар 2020 он



Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сумаар нь харахад 1027 (32.9%) нь Есөнбулаг сумд дийлэнх хувийг эзэлж байгаа бол Алтай сумд 53 (1.7%) нь хамгийн бага хувийг эзэлж байна. Есөнбулаг сумын хөгжлийн бэрхшээлтэй хүний тоог төрлөөр нь авч үзвэл харааны 100 (9.7%), хэл яриа 20 (1.9%), сонсгол 98 (9.5%), хөдөлгөөн 189 (18.4%), сэтгэц 125 (12.3%), хавсарсан 66 (6.4%), бусад 429 (41.8%) нь бэрхшээлтэй хүн байна.

## **Ойлголт, тодорхойлолт:**

“Бүтэн өнчин хүүхэд” гэж эцэг, эх нь тогтоогдоогүй, эсвэл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх /эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг хамруулна /Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7/.

“Хагас өнчин хүүхэд” гэж эцэг эсвэл эх нь тогтоогдоогүй, эцэг эхийн аль нэг нь нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг эсвэл эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэр бүл салсны улмаас эцэг эсвэл эхийн асрамжид орсон 18 хүртэлх насны хүүхдийг хамруулна.

“Өрх толгойлсон эх /эцэг/” гэж нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсвэл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эх /эцэг/ байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг хамааруулна /Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8/. Өрх тэргүүлдэг гэсэн нөхцөл хангагдсан бүх хүнийг насны хязгаар харгалзахгүйгээр өрх толгойлсон эх /эцэг/ -д хамруулна.

### Арван найм хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/

18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-ийн тоог гаргахдаа дараах хүмүүсийг хамруулна. Үүнд:

- Нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан,
- Нөхөр, эхнэрийн аль нэг нь сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон,
- Гэрлэлтээ цуцлуулсан,
- Эх /эцэг/ байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд
- Гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан 18 хүртэлх насны хүүхэдтэй

### Ганц биеэрээ өрх үүсгэн амьдарч буй ахмад настай хүн

Энэ үзүүлэлтээр өрх толгойлон ганц биеэрээ амьдарч буй ахмадын тоог гаргах бөгөөд үүнд өрх үүсгэн ганц биеэр амьдарч буй 55, түүнээс дээш насны эмэгтэй, 60, түүнээс дээш насны эрэгтэйг хамруулна /монгол улсын “ахмад настны тухай” хуулийн 3.1/.

Ганц биеэр өрх үүсгэн амьдарч буй гэдэгт төрөл садангийн хүмүүс байгаад тэдгээрээс тусдаа өрх үүсгэн ганц биеэр амьдарч байгаа болон төрөл садангийн хүн огт байхгүй гэх мэт шалтгаануудыг үл харгалзан ганц биеэрээ амьдарч буй ахмадыг хамруулна.

### Хөгжлийн бэрхшээлтэй хүн

Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэж ойлгоно /Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухайн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1/.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн амд хөдөлмөр магадлах комисс, Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хуралдаанаар орж хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг тогтоолгосон болон тус комиссоор ороогүй боловч тухайн хүн өөрийгөө хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлсон хүн амыг хамруулна.

Хөгжлийн бэрхшээлийн төрлийг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

1. Төрөлхийн: Хөгжлийн бэрхшээлийн төрөлд удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамруулна.

2. Олдмол: Хөгжлийн бэрхшээлийн төрөлд ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамруулна.

Хөгжлийн бэрхшээлийн илэрсэн хэлбэрийг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

1. Харааны: Харах эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “харах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг хамруулна. Хэрэв нүдний шил зүүгээд хэвийн түвшинд хардаг бол харааны бэрхшээлд тооцохгүй.

2. Ярианы: Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин, эмгэгийн улмаас хүний “ярих”, “харилцах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг хамруулна.

3. Сонсголын: Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “сонсох” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг хамруулна. Хэрэв сонсголын төхөөрөмж зүүгээд сонсох түвшин хэвийн түвшинд байдаг бол энд хамруулахгүй.

4. Хөдөлгөөний: Биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадваргүй хүнийг хамруулна.

5. Сэтгэцийн: Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлөвийн, оюун ухааны өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцоо дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан хүнийг хамруулна.

6. Хавсарсан: Нэг хүнд нэгээс дээш төрлийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, согог тохиолдвол хавсарсан хөгжлийн бэрхшээлд хамруулна. Жишээлбэл, хөдөлгөөний болон харааны хөгжлийн бэрхшээлтэй хүнийг харааны болон хөдөлгөөний бэрхшээлтэй хүн амд хамруулахгүйгээр хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүн амд хамруулна.

7. Бусад: Ямар нэгэн эмгэг болон өвчний улмаас өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх чадвараа алдсан хүнийг үүнд хамруулна /Тухайлбал, дотор эрхтний эмгэгүүд, хавдар гэх мэт/.

## V. Нийгмийн даатгал, халамж

### НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын шимтгэлээр 18 тэрбум 804.0 сая төгрөг, тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлийн санхүүжилтээр 25 тэрбум 677.9 сая төгрөг, бүгд 44 тэрбум 481.9 сая төгрөгийн эх үүсвэрийн орлого төвлөрүүлж, тэтгэврийн даатгалын сангаас 8.6 мянган хүнд 36 тэрбум 978.6 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 1583 даатгуулагчид 1559.0 сая, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 25 даатгуулагчидад 99.4 сая, ажилгүйдлийн тэтгэмжид бүртгүүлсэн 211 иргэнд 341.5 сая төгрөгийн зардлыг тус тус бүрэн олгожээ.

### НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн сангаас 2020 онд 31.8 мянган иргэнд 8 тэрбум 752.9 сая төгрөг олгожээ. Үүнээс нийгмийн халамжийн үйлчилгээний зардалд 6 тэрбум 491.0, жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж 19.6, алдарт эхийн одонгийн тусламжид 649.0, хүнс тэжээлд 815.9, алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламжид 66.9, насны хишиг 399.5, цалинтай ээж 131.8 сая, өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж 129.3 сая, ОНОТХҮйлчилгээ 49.9 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

#### **Ойлголт, тодорхойлолт:**

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

# ЭРҮҮЛ МЭНД, 2020 ОНЫ ЭЦСИЙН БАЙДЛААР

Нялхсын эндэгдлийн түвшин  
(1000 амьд төрөлтөд ногдох)

5 хүртэлх насны хүүхдийн  
эндэгдлийн түвшин  
(1000 амьд төрөлтөд ногдох)

2019 I-XII	<b>14.6</b>	<b>19.0</b>
2020 I-XII	<b>8.5</b>	<b>9.2</b>



ЭМНЭЛЭГТ ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧИД		2019 I-XII	<b>13 671</b>	
		2020 I-XII	<b>13 323</b>	




Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид

		2019 I-XII	<b>416</b>
		2020 I-XII	<b>305</b>




## VI.Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар 1395 эх амаржиж, 1406 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 40 (2.9%)-аар, амьд төрсөн хүүхэд 38 (2.8%)-аар тус тус өссөн байна. Нялхсын эндэгдэл 12 болж, өмнөх оны мөн үеэс 8 (40.0%)-аар, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 болж, өмнөх оны мөн үеэс 5 (83.3%)-аар тус тус буурсан байна.




Халдварт өвчнөөр өвчлөгчид 305 болж, өмнөх оны мөн үеэс 111 (26.7%)-аар буурахад салхинцэцэг өвчнөөр өвчлөгчид 57 (65.5%)-аар, заг хүйтэн өвчнөөр өвчлөгчид 25 (42.4%)-аар, тэмбүү өвчнөөр өвчлөгчид 39 (24.7%) буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин хачигт реккетиоз өвчнөөр өвчлөгчид 16 (69.6%) өссөн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид, жил бүрийн эхний 12 сарын байдлаар



Халдварт өвчний төрлөөр 2020 оны 12 сарын байдлаар



### Ойлголт, тодорхойлолт:

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гаргаж авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөх болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.


Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

## VII. Боловсрол

Ерөнхий боловсролын 28 сургууль, 30 цэцэрлэгт өсвөр үеийг сурган хүмүүжүүлж байна. Ерөнхий боловсролын сургуулиудад 11.9 мянган сурагч суралцаж, цэцэрлэгт 4.1 мянган хүүхэд хүмүүжиж байна. Энэ хичээлийн жилд нэгдүгээр ангид 1167 хүүхэд элсэн суралцаж байна.



## ГЭМТ ХЭРЭГ



БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хэргийн төрлөөр, 2020 оны эцсийн байдлаар



ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН ИРГЭД, 2020 оны эцсийн байдлаар

**НИЙТ ДҮН**  
**165**

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ, 2020 оны эцсийн байдлаар




ЭХ ҮҮСВЭР:  
Говь-Алтай аймгийн Цэгдэгийн газрын мэдээлэл


## VIII. Гэмт хэрэг

2020 онд 165 байгууллага, иргэдийн 697.0 сая төгрөгийн өмч хөрөнгөнд хохирол учруулж 151 гэмт хэрэг гарчээ. Эдгээр хэргүүдээс хөнгөн гэмт хэрэг 111 (73.5%), хүнд гэмт хэрэг 40 (26.5%) байна. Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос 84 (35.7%)-аар буурсан байна.

Гэмт хэргийн хэлбэр хувиар, 2020 он




Гэмт хэргийн төрөл хувиар, 2020 онд



Гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл өмчлөх эрхийн 79 (52.3%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 44 (29.1%), залилах гэмт хэрэг 20 (13.2%), хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 3 (1.9%), бусад хэрэг 5 (3.5%) байна. Нийт хэргийн 72 (47.6%) нь Есөнбулаг сумд гарсан хэрэг эзэлж байна.

Гэмт хэрэг, учирсан хохирол 2015-2020 он



Нийт зөрчил 18949 болж өмнөх оны мөн үеэс 3325 (21.3%), баривчлагдсан хүний тоо 266 болж өмнөх оны мөн үеэс 81 (43.8%)-аар тус тус өссөн байна. Харин хүлээн авч шалгасан гомдол, мэдээлэл 1388 болж өмнөх оны мөн үеэс 19 (1.4%), гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 479 болж өмнөх оны мөн үеэс 36 (7.0%)-аар буурсан байна.

Торгуулсан хүн, хуулийн этгээд 18391 байгаа ба өмнөх оны мөн үеэс 3382 (22.5%)-аар өссөн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүний тоо 276 байгаа ба өмнөх оны мөн үеэс 102 (26.9%)-аар буурсан байна.

### **Ойлголт, тодорхойлолт:**

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

## IX. Мөнгө, зээл

Зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 12 сард 124.5 тэрбум төгрөг байгаа ба 0.9 хувийг чанаргүй зээл эзэлж байна.

Харилцахын үлдэгдэл 2020 оны 12 сард 19.3 тэрбум төгрөг байгаа ба үүнээс иргэдийн харилцахын үлдэгдэл 16.4 тэрбум буюу 85.0 хувийг эзэлж байна.

Нийт хадгаламжийн үлдэгдэл 2020 оны 12 сард 127.3 тэрбум төгрөгт хүрчээ.

### ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ БАНКНЫ САЛБАРЫН МЭДЭЭ, 2020 ОН

(Сая төгрөг, тоогоор)

Үзүүлэлт		Үлдэгдэл
Зээл	Нийт зээлийн үлдэгдэл	124,537.7
	Үүнээс: Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл	1,728.2
	Чанаргүй зээлийн үлдэгдэл	1,068.5
Татан төвлөрүүлсэн хөрөнгө	Нийт харилцахын үлдэгдэл	19,282.1
	Үүнээс: Иргэдийн харилцахын үлдэгдэл	16,386.9
	Нийт хадгаламжийн үлдэгдэл	127,260.0
	Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл	122,464.6
	Үүнээс: Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	38,685.1
	Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	88,574.9
Тоон мэдээлэл	Нийт банкны салбар, нэгжийн тоо	45
	Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо	192
	Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор)	23488
	Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	109164
	Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	54683
	Нийт АТМ-ны тоо	27
	Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо	55078

\*Эх үүсвэр: Монгол банк

#### Ойлголт, тодорхойлолт:

Төгрөгийн харилцах дансан дахь мөнгийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Төгрөг болон валютын хадгаламжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Хэвийн зээл гэж төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.


Хугацаа хэтэрсэн зээлийг зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлээр тодорхойлно.

Чанаргүй зээлийг хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлээр тооцож гаргана.

## Х. Төсөв

### ТӨСВИЙН ОРЛОГО


Орон нутгийн төсөвт нийт 72.2 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 102.6 хувиар биелүүлсэн байна. Үүнээс улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг 14.9 тэрбум төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 38.6 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн сан 7.4 тэрбум төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого 9.5 тэрбум төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 120.2 хувиар, хөрөнгийн 29.2 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 2.4 дахин, татварын бус орлого 1 тэрбум төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 111.1 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлэх 1826.6 сая төгрөг, татварын орлого 8.4 тэрбум төгрөгийн орлогыг тус тус оруулсан байна.



### ТӨСВИЙН ЗАРЛАГА

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтийн 92.7 хувийг санхүүжүүлсэн байна. Үүнд бараа, ажил үйлчилгээний зардлын 94.4%, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 96.9%, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 94.4%, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 92.0%, хангамж, бараа материалын зардлын 97.4%, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын 96.4%, эд хогшил, урсгал засварын зардлын 95.9%, томилолт, зочны зардлын 67.5%, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжын 88.9%, бараа үйлчилгээний бусад зардлын 94.6%, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасны 100.0%, урсгал шилжүүлэгийн 96.7 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

### Зардлын төрөл хувиар 2020 онд




## XI. Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн хэмжээнд 2020 оны 12 сард өмнөх оны мөн үеэс 2.8 хувь, өмнөх сараас 0.4 хувиар өссөн байна.

### ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр,

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2020-12 2019-12	2020-12 2019-11
<b>Ерөнхий индекс</b>	<b>100.0</b>	102.8	100.4
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	108.9	99.7
Согтууруулах ундаа, тамхи	3.2	101.4	100.0
Хувцас, бөс бараа, гутал	16.1	104.9	101.7
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	100.6	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	104.0	100.4
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	105.1	100.0
Тээвэр	12.2	94.6	100.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.1	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	101.0	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	100.4	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	100.4	100.0

Ерөнхий индекс 2020 оны 12 сард өмнөх сараас 0.4 хувиар өсөхөд хувцас, бөс бараа, гутал бүлгийн индекс 1.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.



### Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нэг өрхөөс бус нийт өрхөөр тооцогдсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашигладаг. Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.


Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

## ХII.Хөдөө аж ахуй


### МАЛ АЖ АХУЙ

Говь-Алтай аймагт 2020 оны жилийн эцсийн мал тооллогоор 3310.8 мянган толгой мал тоологдсоны дотор адуу 122.1 мянга, үхэр 75.9 мянга, тэмээ 43.9 мянга, хонь 945.7 мянга, ямаа 2123.2 мянган мал тус тус тоологджээ.

#### ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙТ МАЛЫН ТОО, мянган толгой 1940-2020 он



МАЛЫН ТОО, сумаар, 2020 он, /мянган толгой/



Улсад нийт малын тоогоор 11 дүгээр байрт орсон бол тэмээгээр 4 дүгээр байрт, ямааны тоогоор 2 дугаар байрт тус тус орсон байна.

Малын нийт тоо өмнөх оноос 286.9 мянга (8.0%)-аар буурсан байна. үүнээс

**хонь 121.0 мянга (11.3%),**

**ямаа 146.4 мянга (6.5%),**


**адуу 10.3 мянга (7.7%),**

**үхэр 8.6 мянга (10.2%)**

**тэмээ 0.5 мянга (1.1%)-аар тус тус буурчээ.**

Сумдаар авч үзвэл Баян-Уул сумын малын тоо 35.1 мянган толгой буюу 18.2 хувиар, Дарив сумын малын тоо 15.6 мянган толгой буюу 13.0 хувиар, Хөхморьт сумын малын тоо 9.6 мянган толгой буюу 5.7 хувиар, Шарга сумын малын тоо 4.8 мянган толгой буюу 2.9 хувиар тус тус өссөн бол, бусад сумдын малын тоо 0.7-29.3 хувиар буурсан байна.

Малын тоо 2020 онд сумаар, мянган толгой




Малтай 10.9 мянган өрх байгаагийн 7.9 мянга нь 72.4 хувь нь малчин өрх байна. Мөн энэ онд 1000 түүнээс дээш малтай өрхийн тоо 555 болж 2019 оноос 229 өрхөөр (41.3%)-аар буурчээ.




Малчин өрхийн бүлэглэлтээр хамгийн бага хувийг 2001-ээс дээш малтай өрх 16 (0.1%), 201-500 малтай өрх 3770 (34.4%)-ийг эзлэж байна.

Малтай өрхийн тоо өмнөх оноос 434 өрхөөр буюу 4.1 хувиар өссөн байна. 2019 онтой харьцуулхад малтай өрхийг малын тоо бүлэглэлтээр 10 хүртэлх малтай өрх 7.5 хувиар, 501-999 хүртэлх малтай өрх 6.4 хувиар, 1000-1499 малтай өрх 41.5 хувиар 1500-2000 малтай өрх 43.3 хувиар, 2001-ээс дээш малтай өрх 27.3 хувиар буурсан байна.




Мал сүргийн бүтэц, нийт сүрэгт эзлэх хувиар 1990 болон 2020 он



Мал сүргийн бүтэц 1990 оноос 2020 онд орсон өөрчлөлт тэмээ 1.8, адуу 1.1, үхэр 2.4, хонь 29.2 пунктээр тус тус буурсан бол, ямаа 34.5 пунктээр өссөн байна. Энэ өөрчлөлт нь малчдын амьжиргааны эх үүсвэр ноолуур гэдгийг нотлож байна.

**Хээлтэгч мал:** Хээлтэгч мал өмнөх оноос 9.5 хувиар буурч, оны эцсийн байдлаар төллөх насны хээлтэгч 1380.4 мянга болж, нийт малын 41.7 хувийг эзэлж байна. Төрөл дотор гүү 3.0, үнээ 2.3, ингэ 1.1, эм хонь 29.4, эм ямаа 64.2 хувийг тус тус эзэлж байна.

ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ



Нийт төллөх насны хээлтэгчийн 84.7 хувь нь төллөж, үүнээс гүүний 78.9 хувь, үнээний 79.3 хувь, ингэний 53.9 хувь, эм хонины 88.0 хувь, эм ямааны 84.1 хувь нь тус тус төллөсөн байна. Мөн тайлант онд 26.4 мянган хээлтэгч мал хээл хаяж, 202.7 мянган хээлтэгч мал сувайрсан байна.

**Малын хорогдол:** Жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 30.5 мянган толгой том мал зүй бусаар хорогдсон ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8 дахин буурсан байна.

Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 1190, үхэр 1002, тэмээ 184, хонь 8023, ямаа 20083 толгой байна. Нийт хорогдлын 26.3 хувийг хонь, 65.9 хувийг ямаа эзэлж байна.

**Малчдын соёл ахуйн зарим үзүүлэлт:** Аймгийн нийт малчид жилийн дөрвөн улирлын аясаар нүүдэллэж, бэлчээрийн мал аж ахуйгаа маллах явцад соёл ахуйгаа дээшлүүлсээр ирлээ. Тухайлбал: цахилгааны эх үүсгүүртэй өрх 6668, сансрын антентай өрх 5789, телевизортой өрх 6107, радиотой өрх 2849, оёдлын машинтай өрх 3527, угаалгын машинтай 1405 өрх, хөлдөөгчтэй 2165 өрх байна.


**Шинээр гаргасан, засварласан худаг:** Энэ онд инженерийн хийцтэй 3, энгийн уурхайн 9, нийт 12 худаг шинээр гаргаж, 27 худгийг засварлан ашиглажээ.

**Малжуулалтын талаар:** 2020 онд 233 өрхийн 747 ам бүлийг 7140 толгой үүнээс бод 361 толгой, бог 6779 толгой малаар малжуулсан.

## ГАЗАР ТАРИАЛАН

2020 оны байдлаар үр тариа 655.6 тн, төмс 649.6 тн, хүнсний ногоо 549.5 тн, тэжээлийн ургамал 2100.7 тонныг тус тус хурааж аваад байна. Мөн иргэд 8621.1 тн хадлан, 691.8 тн гар тэжээл, 3073.3 тн хужир шүү тус тус бэлтгэсэн байна.

Хураасан ургац, жил бүрийн 12 сарын байдлаар



### Ойлголт, тодорхойлолт:

Төл бойжилтын хувь: Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Том малын зүй бус хорогдол: Өвчнөөр (халдвартай, халдваргүй) болон гэнэтийн аюулаар (цас, зуд, үер, ус, гал түймэр, аянга, цахилгаан зэрэг) хорогдсон, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) улмаас хорогдсон малыг хамруулна.

Нийт хураасан ургац: Тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг таримал ургамлын хэмжээгээр тодорхойлно.

Га-гийн ургац: Талбайн нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ юм. Га-гийн ургацыг тодорхойлохдоо нэг төрлийн ургамал тариалсан талбайгаас хураан авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулна.

АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2020\* ОНЫ ЭЦСИНГЭЙН БАЙДЛААР



АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ



### XIII. Аж үйлдвэр


Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 14 тэрбум 270.3 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 15.1 хувиар буурчээ. Үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1 тэрбум 287.0 сая төгрөг буюу нийт үйлдвэрлэлийн 9 хувь, боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэл 1 тэрбум 65.8 сая төгрөг буюу 7.5 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж 11 тэрбум 917.5 сая төгрөг буюу 83.5 хувийг тус тус эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл салбараар, 12 сар, хувиар



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны 12 дугаар сард 1 тэрбум 687.8 сая төгрөгт хүрч өмнөх сараас 81.7 сая төгрөгөөр өсжээ. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 23.8 (13.0%) сая төгрөгөөр буурч, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 86.6 (93.7%) сая төгрөгөөр, цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамж үйлдвэрлэл 18.9 (1.4%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, 12 сар, сая төгрөг



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 14 тэрбум 940.1 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 13.9 хувиар буурчээ. Үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулалт 1 тэрбум 471.7 (9.9%), боловсруулах аж үйлдвэрийн салбарын борлуулалт 1 тэрбум 253.1 (8.4%) сая төгрөг,

цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамжийн салбарын борлуулалт 12 тэрбум 215.3 (81.7%) сая төгрөг байна.

Салбар	2019		2020*		Дүнд эзлэх хувь
	XII	I-XII	XII	I-XII*	
	мянган төгрөг				
<b>Нийт дүн</b>	<b>2505806.5</b>	<b>17346721.1</b>	<b>1786703.0</b>	<b>14940091.6</b>	<b>100.0</b>
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	169347.0	1255412.5	167500.0	1471669.8	9.9
Боловсруулах аж үйлдвэр	1289578.1	2331292.3	203597.4	1253111.6	8.4
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	1046881.4	13760016.3	1415605.6	12215310.2	81.7

### **Ойлголт, тодорхойлолт:**


Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал: НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд нийцүүлэн боловсруулсан үндэсний ангилал юм.

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.


## 2021 ОНЫ I САРААС 2021 ОНЫ III САРЫН ЦАГ АГААРЫН МЭДЭЭ

**Нэгдүгээр сард.** Сарын дундаж агаарын температур ожд–аар говь-алтайн өмнөд хэсгээр 10-16°С, бусад нутгаар 18-26°С хүйтэн байдаг. 1 дүгээр сарын агаарын дундаж температур говь-алтайн нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**зураг 1**). сарын нийлбэр хур тунадас ожд–аар говь-алтайн нутгаар 1-2 мм цас ордог. 1 дүгээр сарын нийлбэр хур тунадас говь-алтайн нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй байна (**зураг 2**).



Зураг 1. 2021 оны 1 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан төлөв(°С)

[Х – агаарын температур ОЖД – аас хүйтэн, Н – агаарын температур ОЖД – ийн орчим]




Зураг 2. 1 дүгээр сарын хур тунадасны урьдчилсан төлөв(мм)

[И – хур тунадас ОЖД – аас их, Б – хур тунадас ОЖД – аас бага]


Н – агаарын температур, хур тунадас ОЖД – ийн орчим]

**Хоёрдугаар сард.** Сарын дундаж агаарын температур ожд–аар говь-алтайн өмнөд хэсгээр 6-12°С, бусад нутгаар 14-22°С хүйтэн байдаг. 2 дугаар сарын агаарын дундаж температур говь-алтайн нутгаар дунджийн орчим байна (**зураг 3**). Сарын нийлбэр хур тунадас ожд–аар говь-алтайн зарим нутгаар 2-4 мм, бусад нутгаар 0-2 мм цас ордог. 2 дугаар сарын нийлбэр хур тунадас говь-алтайн нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй (**зураг 4**).



Зураг 3. 2 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөө(°C)

[Д - агаарын температур ОЖД - аас дулаан, Н - агаарын температур ОЖД - ийн орчим]




Зураг 4. 2 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөө(мм)

[И - хур тунадас ОЖД - аас ахиу, Б - хур тунадас ОЖД - аас бага


Н - агаарын температур, хур тунадас ОЖД - ийн орчим]

**Гуравдугаар сард.** Сарын дундаж агаарын температур ожд-аар говь-алтайн өмнөд хэсгээр 4°с хүйтнээс 2°с дулаан, бусад нутгаар 4-12°с хүйтэн байдаг. 3 дугаар сарын агаарын дундаж температур. Говь-Алтайн зарим сумдын нутгаар ожд-ийн орчим, бусад нутгаар дунджаас дулаан байх төлөвтэй байна (**зураг 5**). Сарын нийлбэр хур тунадас ожд-аар говь-алтайн нутгаар 0-4 мм хур тунадас ордог. 3 дугаар сарын нийлбэр хур тунадас говь-алтайн зарим сумдын нутгаар ожд - аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй байна (**зураг 6**).



Зураг 5. 3 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв(°C)

[Д - агаарын температур ОЖД - аас дулаан, Н - агаарын температур ОЖД - ийн орчим]



Зураг 6. 3 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв(мм)

[И - хур тунадас ОЖД - аас их, Б - хур тунадас ОЖД - аас бага]

Н - агаарын температур, хур тунадас ОЖД - ийн орчим]

ЭХ ҮҮСВЭР: УЦУОШТ МҮХЭЛТЭС УТАС: 70483093

## XIV. Хавсралт

Сум	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
	аймгийн хүн ам population of aimag							
<b>Бүгд</b>	<b>56208</b>	<b>56698</b>	<b>56018</b>	<b>56694</b>	<b>57441</b>	<b>58280</b>	<b>57479</b>	<b>58343</b>
Есөнбулаг	19053	18678	17802	18108	18470	18931	18444	18739
Алтай	2122	2022	2102	2082	2063	2056	2056	2091
Баян-уул	2860	3062	2984	3000	3002	3026	3006	3044
Бигэр	2168	2148	2113	2139	2211	2243	2243	2253
Бугат	2008	2195	2186	2191	2168	2210	2156	2178
Дарви	1768	1814	1819	1852	1844	1860	1772	1788
Дэлгэр	2979	3022	3023	3060	3127	3146	3139	3163
Жаргалан	1652	1736	1752	1785	1802	1826	1805	1837
Тайшир	1361	1426	1470	1550	1606	1599	1619	1649
Тонхил	2025	2204	2142	2152	2197	2222	2232	2265
Төгрөг	1890	1972	2014	2054	2054	2034	2050	2095
Халиун	2398	2311	2367	2388	2407	2458	2420	2445
Хөхморьт	2236	2320	2332	2379	2373	2367	2353	2356
Цогт	3442	3387	3513	3549	3579	3585	3503	3544
Цээл	2008	2102	2101	2109	2164	2207	2226	2271
Чандмана	2130	2139	2176	2180	2218	2247	2216	2290
Шарга	1947	1980	1971	1937	1937	1936	1957	1993
Эрдэнэ	2161	2180	2151	2179	2219	2327	2282	2342


Сум	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
	Хүн амын нягтшил/1км <sup>2</sup> -д ногдох хүнээр/							
<b>Бүгд</b>	<b>0.4</b>	<b>0.4</b>	<b>0.4</b>	<b>0.4</b>	<b>0.4</b>	<b>0.4</b>	<b>0.4</b>	<b>0.4</b>
Есөнбулаг	8.8	8.6	8.2	8.4	8.5	8.8	8.5	8.7
Алтай	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1
Баян-уул	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5
Бигэр	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6
Бугат	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2
Дарви	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5
Дэлгэр	0.4	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5
Жаргалан	0.4	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5
Тайшир	0.3	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4
Тонхил	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3
Төгрөг	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4
Халиун	0.5	0.4	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5
Хөхморьт	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4
Цогт	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2
Цээл	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4
Чандмана	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5
Шарга	0.3	0.4	0.4	0.3	0.3	0.3	0.4	0.4
Эрдэнэ	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1

**Говь-алтай аймагт оршин суугаа иргэдийн тоо, сумаар, байршлаар, 2020 он**

сум	бүх хүн ам			үүнээс											
	бүгд	эрэгтэй	эмэгтэй	аймгийн төвд			тосгонд			сумын төвд			хөдөөд		
				бүгд	эрэгтэй	эмэгтэй	бүгд	эрэгтэй	эмэгтэй	бүгд	эрэгтэй	эмэгтэй	бүгд	эрэгтэй	эмэгтэй
<b>Бүгд</b>	<b>58343</b>	<b>29134</b>	<b>29209</b>	<b>17448</b>	<b>8534</b>	<b>8914</b>	<b>1516</b>	<b>748</b>	<b>768</b>	<b>12046</b>	<b>6016</b>	<b>6030</b>	<b>27333</b>	<b>13836</b>	<b>13497</b>
Есөнбулаг	18739	9181	9558	17448	8534	8914	0	0	0	0	0	0	1291	647	644
Алтай	2091	1046	1045	0	0	0	0	0	0	958	479	479	1133	567	566
Баян-уул	3044	1525	1519	0	0	0	0	0	0	1136	572	564	1908	953	955
Бигэр	2253	1117	1136	0	0	0	0	0	0	726	354	372	1527	763	764
Бугат	2178	1080	1098	0	0	0	0	0	0	341	160	181	1837	920	917
Дарви	1788	880	908	0	0	0	0	0	0	343	172	171	1445	708	737
Дэлгэр	3163	1563	1600	0	0	0	726	348	378	496	238	258	1941	977	964
Жаргалан	1837	946	891	0	0	0	0	0	0	349	179	170	1488	767	721
Тайшир	1649	862	787	0	0	0	0	0	0	330	173	157	1319	689	630
Тонхил	2265	1124	1141	0	0	0	0	0	0	845	419	426	1420	705	715
Төгрөг	2095	1084	1011	0	0	0	0	0	0	832	433	399	1263	651	612
Халиун	2445	1268	1177	0	0	0	0	0	0	653	334	319	1792	934	858
Хөхморьт	2356	1208	1148	0	0	0	0	0	0	368	177	191	1988	1031	957
Цогт	3544	1768	1776	0	0	0	790	400	390	671	334	337	2083	1034	1049
Цээл	2271	1154	1117	0	0	0	0	0	0	1206	612	594	1065	542	523
Чандмана	2290	1165	1125	0	0	0	0	0	0	1021	515	506	1269	650	619
Шарга	1993	993	1000	0	0	0	0	0	0	829	396	433	1164	597	567
Эрдэнэ	2342	1170	1172	0	0	0	0	0	0	942	469	473	1400	701	699

### ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР, 2013-2020 ОН

НАСНЫ БҮЛЭГ	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
<b>БҮГД</b>	<b>56208</b>	<b>56698</b>	<b>56018</b>	<b>56694</b>	<b>57441</b>	<b>58280</b>	<b>57479</b>	<b>58343</b>
0-4	5959	5953	6306	6100	6072	6227	6204	6449
5-9	5290	5392	5652	5837	6023	6169	6039	6094
10-14	5530	5046	4997	4886	4937	5145	5338	5479
15-19	6614	5778	5345	5472	5427	5263	4883	4780
20-24	4453	5631	4886	4810	4895	5087	4840	4911
25-29	4694	4837	4637	4675	4618	4432	4233	4275
30-34	4394	4401	4463	4513	4506	4490	4339	4227
35-39	4373	4345	4204	4297	4255	4227	4183	4259
40-44	3932	3994	3974	3989	4113	4139	4089	4032
45-49	3279	3389	3487	3597	3646	3755	3759	3817
50-54	2711	2730	2742	2888	2972	3056	3136	3281
55-59	1870	1974	2069	2171	2302	2458	2463	2500
60-64	938	1064	1139	1314	1491	1601	1655	1798
65-69	725	706	706	699	720	758	843	961
70-74	674	706	637	611	589	587	565	570
75-79	451	419	460	497	492	473	509	472
80-84	202	225	205	223	265	284	253	293
85-89	74	63	72	75	76	89	114	109
90-94	43	40	29	31	31	28	25	29
95-99	2	5	8	8	10	12	7	6
100+	0	0	0	1	1	0	2	1



**ХҮН АМЫН ТОО, ЭРЭГТЭЙ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2013-2020 ОН**

НАСНЫ БҮЛЭГ	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
<b>БҮГД</b>	27279	28095	27860	28190	28608	29030	28649	29134
0-4	3002	3098	3260	3126	3133	3250	3219	3398
5-9	2711	2786	2899	3000	3134	3156	3122	3164
10-14	2795	2561	2529	2502	2515	2643	2764	2817
15-19	2924	3009	2742	2787	2753	2683	2521	2440
20-24	2282	2708	2489	2451	2518	2603	2462	2532
25-29	2352	2481	2398	2410	2388	2275	2156	2169
30-34	2189	2226	2243	2321	2296	2291	2199	2169
35-39	2160	2123	2128	2152	2133	2121	2109	2120
40-44	1982	2024	1979	1950	2039	2045	2009	2036
45-49	1585	1661	1712	1788	1802	1890	1902	1884
50-54	1282	1297	1327	1405	1466	1467	1523	1590
55-59	872	901	939	999	1028	1129	1128	1173
60-64	369	449	482	560	664	713	725	781
65-69	276	246	235	241	240	279	328	387
70-74	268	290	258	233	216	200	179	179
75-79	146	145	158	176	178	165	190	173
80-84	55	62	56	60	80	89	76	85
85-89	20	17	17	19	16	21	27	28
90-94	9	9	8	7	5	7	7	7
95-99	0	2	1	3	4	3	2	2
100+	0	0	0	0	0	0	1	0


**ХҮН АМЫН ТОО, ЭМЭГТЭЙ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2013-2020 ОН**

НАСНЫ БҮЛЭГ	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
<b>БҮГД</b>	28929	28603	28158	28504	28833	29250	28830	29209
0-4	2957	2855	3046	2974	2939	2977	2985	3051
5-9	2579	2606	2753	2837	2889	3013	2917	2930
10-14	2735	2485	2468	2384	2422	2502	2574	2662
15-19	3690	2769	2603	2685	2674	2580	2362	2340
20-24	2171	2923	2397	2359	2377	2484	2378	2379
25-29	2342	2356	2239	2265	2230	2157	2077	2106
30-34	2205	2175	2220	2192	2210	2199	2140	2058
35-39	2213	2222	2076	2145	2122	2106	2074	2139
40-44	1950	1970	1995	2039	2074	2094	2080	1996
45-49	1694	1728	1775	1809	1844	1865	1857	1933
50-54	1429	1433	1415	1483	1506	1589	1613	1691
55-59	998	1073	1130	1172	1274	1329	1335	1327
60-64	569	615	657	754	827	888	930	1017
65-69	449	460	471	458	480	479	515	574
70-74	406	416	379	378	373	387	386	391
75-79	305	274	302	321	314	308	319	299
80-84	147	163	149	163	185	195	177	208
85-89	54	46	55	56	60	68	87	81
90-94	34	31	21	24	26	21	18	22
95-99	2	3	7	5	6	9	5	4
100+	0	0	0	1	1	0	1	1

### ХҮЙСИЙН ХАРЬЦАА 2013-2020 ОН

НАСНЫ БҮЛЭГ	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
ХҮЙСИЙН ХАРЬЦАА								
<b>БҮГД</b>	94.3	98.2	98.9	98.9	99.2	99.2	99.4	99.7
0-4	101.5	108.5	107.0	105.1	106.6	109.2	107.8	111.4
5-9	105.1	106.9	105.3	105.7	108.5	104.7	107.0	108.0
10-14	102.2	103.1	102.5	104.9	103.8	105.6	107.4	105.8
15-19	79.2	108.7	105.3	103.8	103.0	104.0	106.7	104.3
20-24	105.1	92.6	103.8	103.9	105.9	104.8	103.5	106.4
25-29	100.4	105.3	107.1	106.4	107.1	105.5	103.8	103.0
30-34	99.3	102.3	101.0	105.9	103.9	104.2	102.8	105.4
35-39	97.6	95.5	102.5	100.3	100.5	100.7	101.7	99.1
40-44	101.6	102.7	99.2	95.6	98.3	97.7	96.6	102.0
45-49	93.6	96.1	96.5	98.8	97.7	101.3	102.4	97.5
50-54	89.7	90.5	93.8	94.7	97.3	92.3	94.4	94.0
55-59	87.4	84.0	83.1	85.2	80.7	85.0	84.5	88.4
60-64	64.9	73.0	73.4	74.3	80.3	80.3	78.0	76.8
65-69	61.5	53.5	49.9	52.6	50.0	58.2	63.7	67.4
70-74	66.0	69.7	68.1	61.6	57.9	51.7	46.4	45.8
75-79	47.9	52.9	52.3	54.8	56.7	53.6	59.6	57.9
80-84	37.4	38.0	37.6	36.8	43.2	45.6	42.9	40.9
85-89	37.0	37.0	30.9	33.9	26.7	30.9	31.0	34.6
90-94	26.5	29.0	38.1	29.2	19.2	33.3	38.9	31.8
95-99	0.0	66.7	14.3	60.0	66.7	33.3	40.0	50.0
100+	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	100.0	0.0

### Хүйсийн харьцаа 2013-2020 он




**ХҮН АМЫН ТОО, БАГААР, 2020 ОН**

Баг	БҮХ ХҮН АМ			Баг	БҮХ ХҮН АМ		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
	<b>58343</b>	<b>29134</b>	<b>29209</b>	1-р баг, Бүс-Уул	464	238	226
1-р баг, Баянхайрхан	2189	1063	1126	2-р баг, Тамч	515	249	266
2-р баг, Баяншанд	2297	1117	1180	3-р баг, Зүйл	376	190	186
3-р баг, Жаргалант	2126	1045	1081	4-р баг, Алтансоёмбо	396	192	204
4-р баг, Харзат	2016	962	1054	5-р баг, Алтайн-	514	255	259
5-р баг, Рашаант	735	371	364	<b>Тонхил сум</b>	<b>2265</b>	<b>1124</b>	<b>1141</b>
6-р баг, Наран	556	276	280	1-р баг, Хүрэн гол	537	273	264
7-р баг, Жинст	2200	1084	1116	2-р баг, Төгрөгийн эх	549	276	273
8-р баг, Индэрт	2079	1029	1050	3-р баг, Мааньт	342	180	162
9-р баг, Түмэн	2031	970	1061	4-р баг, Цагаан	352	182	170
10-р баг, Оргил	2510	1264	1246	5-р баг, Тунгалаг	315	173	142
<b>Есөнбулаг сум</b>	<b>18739</b>	<b>9181</b>	<b>9558</b>	<b>Төгрөг сум</b>	<b>2095</b>	<b>1084</b>	<b>1011</b>
1-р баг, Бадрал	397	194	203	1-р баг, Сүүж	705	357	348
2-р баг, Баянцагаан	337	161	176	2-р баг, Гүү бариач	629	330	299
3-р баг, Урт	399	212	187	3-р баг, Олон булаг	633	337	296
4-р баг, Баян-Овоо	958	479	479	4-р баг, Чацран	478	244	234
<b>Алтай сум</b>	<b>2091</b>	<b>1046</b>	<b>1045</b>	<b>Халиун сум</b>	<b>2445</b>	<b>1268</b>	<b>1177</b>
1-р баг, Баян богд	424	203	221	1-р баг, Цоохор	508	266	242
2-р баг, Чандмань	453	229	224	2-р баг, Завхан гол	490	257	233
3-р баг, Баянхайрхан	541	279	262	3-р баг, Сангийн	447	236	211
4-р баг, Хүйсийн говь	409	204	205	4-р баг, Хүйсийн говь	543	272	271
5-р баг, Баянговь	626	310	316	5-р баг, Сайн-Уст	368	177	191
